

## КАСТОДИАН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журам нь “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ТӨХХК нь (цаашид Төвлөрсөн хадгаламжийн төв гэх) Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид “Хороо” гэх)-ноос кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан этгээдийг гишүүнчлэлээр элсүүлэхэд тавигдах шаардлага, тэднийг кастодиан гишүүнээр бүртгэх, бүртгэлээс хасах, мэдээ мэдээлэл солилцох, түүнд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэхүү харилцаанд Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Монгол банкны ерөнхийлөгч, Хорооны даргын хамтарсан тушаалаар батлагдсан “Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”, “Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль”, “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”, Төвлөрсөн хадгаламжийн төвийн “Үнэт цаасны хадгаламжийн журам”, “Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх бүртгэх үйл ажиллагааны журам” болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.3 Энэхүү журамд зохих нэмэлт өөрчлөлтийг “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл оруулана.

### Хоёр. Журамд хэрэглэгдэх нэр томъёо

2.1 Энэхүү журамд дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно. Үүнд:

2.1.1 “Кастодианы үйл ажиллагаа” гэж “Үнэт Цаасны Зах Зээлийн Тухай Хууль”-ийн 46.1-т зааснаар;

2.1.2 “Кастодиан гишүүн” гэж кастодиан үйлчилгээ үзүүлэхээр Хорооноос тусгай зөвшөөрөл авсан, уг журмын 3 дугаар зүйлд заасан төвлөрсөн хадгаламжийн төвөөс тавих шаардлагыг бүрэн хангасан хуулийн этгээд буюу “Үнэт Цаасны Зах Зээлийн Тухай Хууль”-ийн 46.2-т заасан нэгжийг;

2.1.3 “Номиналь эзэмшигч” гэж “Үнэт Цаасны Зах Зээлийн Тухай Хууль”-ийн 4.1.25-д зааснаар;

2.1.4 “Бенефициар өмчлөгч” гэж “Үнэт Цаасны Зах Зээлийн Тухай Хууль”-ийн 4.1.26-д зааснаар;

2.1.5 “Номиналь данс” гэж Хорооны “Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ын 1.6.5-д зааснаар тус тус ойлгоно.

### Гурав. Гишүүнд тавигдах шаардлага

3.1 Төвлөрсөн хадгаламжийн төвийн гишүүнээр бүртгүүлэх хүсэлтэй кастодиан банк Хорооноос кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан этгээд байна.

3.2 Төвлөрсөн хадгаламжийн төвийн гишүүнээр бүртгүүлэхэд кастодиан банк дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.2.1 Хорооноос кастодианы үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан байх;

3.2.2 Журмын 7 дугаар зүйлд заасан гишүүнчлэлийн хураамжийг төлж, гэрээ байгуулсан байх;

3.3 Төвлөрсөн хадгаламжийн төвд данс нээлгэхийн тулд хүсэлт гаргагч нь журмын 3.2-т заасан шаардлагуудыг хангасан тохиолдолд энэхүү журмын “Төвлөрсөн хадгаламжийн гишүүнчлэлийн гэрээ” (Хавсралт 1)-г бөглөж, дор дурьдсан баримт бичгийн бүрдүүлбэрийн хамт төвлөрсөн хадгаламжийн төвд хүргүүлнэ. Үүнд:

3.3.1 Уг журмын 7 дугаар зүйлд заасан гишүүнчлэлийн хураамжийг төлсөн баримтын эх хувь;

3.3.2 Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар;

3.3.3 Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;

3.3.4 Гишүүнээр бүртгүүлэхээр өргөдөл гаргагчийн сүүлийн 3 жилийн аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн хуулбар;

3.3.5 Данс нээлгэх хүсэлт бүхий албан бичиг;

3.3.6 Захиран зарцуулагч томилсон ТУЗ-ийн, эсвэл гүйцэтгэх удирдлагын шийдвэрийн хуулбар;

3.3.7 Данс захиран зарцуулагчийн гарын үсгийн баталгаа (нотариатаар баталгаажуулсан);

3.3.8 Захиран зарцуулагчийн иргэний үнэмлэхийн хуулбар;

3.3.9 Үнэт цаасны зах зээл дээр ажил үйлчилгээ явуулах үнэмлэхийн хуулбар тус тус байна.

3.4 Төвлөрсөн хадгаламжийн төв нь хүсэлт гаргагчаас ирүүлсэн баримт бичиг, шаардлага бүрэн хангагдсан гэж үзвэл өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор хадгаламжийн системд бүртгэнэ.

3.5 Төвлөрсөн хадгаламжийн төв нь энэхүү журмын 3.2-т заасан шаардлага, 3.3-т заасан баримтын бүрдлийг кастодиан банк хангаагүй гэж үзвэл өргөдлийг хүлээн авахаас татгалзаж, баримтыг ажлын 3 хоногийн дотор буцаан олгоно.

#### **Дөрөв. Гишүүнд код олгох, төвлөрсөн хадгаламжид данс нээх**

4.1 Төвлөрсөн хадгаламжийн төв нь журмын 3 дугаар зүйлд тавигдах шаардлагыг хангасан этгээдийг гишүүнчлэлээр бүртгэж, 3-10 орон бүхий латин үсгэн код олгоно.

4.2 Хорооны “Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ын 5.8.3-т зааснаар төвлөрсөн хадгаламжид дараах дансыг нээнэ. Үүнд:

4.2.1 Өөрийн данс;

4.2.2 Номиналь данс;

4.2.3 Нээлтэй буюу шууд эзэмшлийн данс;

4.3 Уг журмын 4.2.1-т заасан данс нь гишүүний эзэмшиж буй үнэт цаасыг хадгалах түүнтэй холбоотой өмчлөх эрх бүртгэлийг өөрийн захиран зарцуулагчаар дамжуулан хийлгүүлэх, гишүүний нэр дээр нээлгэсэн төвлөрсөн хадгаламжийн данс байна.

4.4 Уг журмын 4.2.2-т заасан данс нь Хорооны “Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ын 5.8-д зааснаар буюу өөрийн бенефициар өмчлөгчийн үнэт цаасыг хадгалах, түүнтэй холбоотой өмчлөх эрхийн бүртгэлийг хэрэгжүүлэхээр Төвлөрсөн хадгаламжийн төвд нээлгүүлсэн данс байна.

4.5 Уг журмын 4.2.3-т заасан данс нь Хорооны “Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ын 5.9-д зааснаар харилцагч кастодиан банкаар дамжуулан Төвлөрсөн хадгаламжийн төвд нээлгэсэн бенефициар данс буюу шууд эзэмшлийн данс байна.

4.6 Уг журмын 4.2-т заасан өөрийн, номиналь, нээлттэй буюу шууд эзэмшлийн дансуудыг гишүүн кастодиан банк хоёр ба түүнээс дээш тоогоор Төвлөрсөн хадгаламжийн төвд нээлгэж болно.

### **Тав. Талуудын эрх, үүрэг**

#### **5.1 Гишүүн дараах эрхтэй. Үүнд:**

5.1.1 Гишүүн нь төвлөрсөн хадгаламжийн төвөөс дансны талаарх хувь хүн, байгууллагын нууцад хамаарагдахгүй тодорхойлолт, мэдээ судалгаа, тайланг гаргуулж авна. Үүнд:

5.1.1.1 Харилцагчийн мэдээлэл

5.1.1.2 Харилцагчийн дансны үлдэгдлийн мэдээлэл

5.1.1.3 Арилжааны дүнд үүссэн төлбөрийн мэдээ

5.1.1.4 Үнэт цаасны мэдээлэл

5.1.1.5 Арилжааны мэдээ

5.1.1.6 Арилжааны бус гүйлгээний мэдээ

5.1.2 Төвлөрсөн хадгаламжийн төвийг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

5.1.3 Хорооны журмын 3.12.11, 3.12.4, 3.12.5, 3.12.7 заалтуудад заасны дагуу болон анхдагч зах зээлийн арилжаанд оролцохтой холбоотой харилцагчийн байршуулсан хөрөнгийн үлдэгдлийг гишүүн байгууллага нь үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ харилцагчийг төлөөлж харилцагчийн арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгийн дансанд орлого хүлээн авах;

5.1.4 Шаардлагатай тохиолдолд Төвлөрсөн хадгаламжийн төвтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр данс нээх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

5.1.5 Гишүүн нь харилцагчийн нэрийн өмнөөс эсхүл түүнийг төлөөлөн ногдол ашиг, хүүгийн орлого хүлээж авах, хувьцаат компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг хүлээн авах эрхтэй.

#### **5.2 Гишүүн дараах үүрэгтэй. Үүнд:**

5.2.1 Гишүүн нь хамтын номиналь данс дахь үнэт цаасны мэдээллийг Төвлөрсөн хадгаламжийн төвд тухайн өдрөөр анх хадгалуулах зорилгоор “Кастодиан гишүүний үнэт

цаасны өмчлөх эрхийн бүртгэл” (Хавсралт 3)-ийг бөглөж үнэт цаасны өмчлөх эрхтэй холбоотой бүртгэлийг Төвлөрсөн хадгаламжийн төвөөр баталгаажуулах;

5.2.2 Номиналь дансуудад өмчлөх эрх шилжүүлгийн гүйлгээг Төвлөрсөн хадгаламжийн төвийн “Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх бүртгэх үйл ажиллагааны журам”-ын дагуу хийлгэх;

5.2.3 Өмчлөх эрхийн бүртгэлд өөрчлөлт орсон тохиолдолд Төвлөрсөн хадгаламжид зохих өөрчлөлтийг холбогдох системийн дагуу тухайн өдөр өндөрлөх бүрт мэдээ болгон хүргүүлэх;

5.2.4 Гишүүний байршил, утасны дугаар болон бусад мэдээлэл, хамтын дансуудыг захиран зарцуулагч өөрчлөгдөх зэрэг үйл ажиллагаатай холбоотой өөрчлөлтүүдийг тухай бүр төвлөрсөн хадгаламжийн төвд албан ёсоор мэдэгдэх;

5.2.5 Гишүүн нь уг журмын 7 дугаар зүйлд заасан гишүүнчлэлийн хураамж болон хадгаламжийн үйлчилгээний хөлс, үйлчилгээний хөлс зэргийг заасан хугацаанд төлөх;

5.2.6 Гишүүн нь энэхүү журмын “Төвлөрсөн хадгаламжийн гишүүнчлэлийн гэрээ” (Хавсралт 1)-ний дагуу үйлчилгээний хөлсийг улирал бүрийн эхний 7 хоногт Төвлөрсөн хадгаламжийн төвд төлөх;

5.2.7 Бенефициар өмчлөгчийн дансууд дахь үнэт цаасны өмчлөх эрх бүртгэлийн мэдээллийг бусдад дамжуулахгүй байх, нууцлалыг хадгалах;

5.2.8 Гишүүн нь өөрийн данс дотоод бүртгэлийг Төвлөрсөн хадгаламжийн төвөөс хүлээн авсан тодорхойлолт, мэдээ судалгаа, тайлантай өдөр бүр тулгалт хийж, Төвлөрсөн хадгаламжийн холбогдох системийн дагуу баталгаажуулах;

5.2.9 Гишүүн нь харилцагчид болон Төвлөрсөн хадгаламжийн төвд үнэн зөв мэдээ, мэдээлэл өгөх үүрэгтэй.

5.3 Төвлөрсөн хадгаламжийн төв дараах эрхтэй. Үүнд:

5.3.1 Төвлөрсөн хадгаламжийн төв нь гишүүнээс дансуудын талаарх хувь хүн болон байгууллагын нууцад хамаарагдахгүй тодорхойлолт, мэдээ судалгаа, тайланг гаргуулж авах;

5.3.2 Гишүүнийг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

5.3.3 Шаардлагатай тохиолдолд гишүүн байгууллагатай харилцан тохиролцсоны үндсэн дээр “Төвлөрсөн хадгаламжийн гишүүнчлэлийн гэрээ” (Хавсралт 1)-нд нэмэлт, өөрчлөлт оруулах;

5.3.4 Гишүүн нь “Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлд заасан кастодианы үйл ажиллагаа, болон үзүүлэх үйлчилгээ хууль, дүрэм, журамтай үл нийцсэн үйл ажиллагаа явуулсан буюу дээрх журмын заалтуудыг зөрчсөн эсвэл Төвлөрсөн хадгаламжийн төвөөс тавьсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд Төвлөрсөн хадгаламжийн төв нь “Төвлөрсөн хадгаламжийн гишүүнчлэлийн гэрээ” (Хавсралт 1)-г цуцлах эрхтэй.

#### 5.4 Төвлөрсөн хадгаламжийн төв дараах үүрэгтэй. Үүнд:

5.4.1 Төвлөрсөн хадгаламжийн төв нь гишүүнд уг журмын 5.1.1-д заасны дагуу гишүүн этгээдийн хувь хүн болон байгууллагын нууцад хамаарагдахгүй тодорхойлолт, мэдээ судалгаа, тайланг ажлын 5 өдрийн дотор гаргаж өгөх;

5.4.2 Үнэт цаас гаргагч нь Төвлөрсөн хадгаламжийн төвтэй ногдол ашиг болон ногдол хувь тараах гэрээ, хэлцэл хийсэн нөхцөлд энэхүү мэдээллийг Төвлөрсөн хадгаламжийн төв нь гишүүнд ажлын 3 хоногийн дотор албан ёсоор мэдэгдэх;

5.4.3 Төвлөрсөн хадгаламж дахь үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлд өөрчлөлт орсон тохиолдолд зохих өөрчлөлтийг холбогдох маягт (Хавсралт 3) болон системийн дагуу тухайн өдөр өндөрлөх бүрт гишүүн байгууллагад мэдээ (Хавсралт 4) болгон хүргүүлэх;

5.4.4 Төвлөрсөн хадгаламжийн төвийн байршил, утасны дугаар болон бусад ерөнхий мэдээлэл, өмчлөх эрх бүртгэлтэй холбоотой болон үнэт цаас шилжүүлэх зэрэг үйл ажиллагаатай уялдсан өөрчлөлтүүдийг тухай бүр гишүүн байгууллагад албан ёсоор мэдэгдэх;

5.4.5 Гишүүн байгууллагатай байгуулсан “Төвлөрсөн хадгаламжийн гишүүнчлэлийн гэрээ” (Хавсралт 1)-г цуцлах тохиолдолд Хороо болон Монгол банкинд энэ тухайгаа ажлын 5 хоног дотор албан ёсоор мэдэгдэх;

5.4.6 Бенефициар өмчлөгчийн болон гишүүн байгууллагын тухайн дансан дахь үнэт цаасны өмчлөх эрх бүртгэлийн мэдээллийг бусдад дамжуулахгүй байх, нууцлалыг хадгалах;

5.4.7 Төвлөрсөн хадгаламжийн төв нь уг журмын 5.1.1-д заасан тодорхойлолт, мэдээ судалгаа, тайланг гишүүн байгууллагад өдөр бүр холбогдох системийн дагуу мэдээлэх;

5.4.8 Төвлөрсөн хадгаламжийн төв нь гишүүн байгууллагад үнэн зөв мэдээ, мэдээлэл өгөх.

#### **Зургаа. Дансны мэдээлэл дамжуулах**

6.1 Гишүүн нь Төвлөрсөн хадгаламжийн төвөөс доорх ажилбарын дагуу тодорхойлолт, мэдээ судалгаа, тайланг хүлээн авч үнэт цаасны өмчлөх эрхийн тулгалт хийх ажилбарыг хэрэгжүүлнэ. Үүнд:

6.1.1 Уг журмын 3.5-д заасан бүртгэлийн дагуу гишүүнд Төвлөрсөн хадгаламжийн төвийн Мэдээлэл технологийн албанаас системд нэвтрэх эрх олгоно.

6.1.2 6.1.1-д заасан нэвтрэх эрхтэй гишүүн нь үнэт цаасны дансуудтай холбоотой мэдээ мэдээлэл, тайлан судалгааг уг журмын 5.1.1-д заасанчлан хүлээн авч үнэт цаасны үлдэгдэлийн тулгалт хийнэ.

6.1.3 Гишүүн системд нэвтэрч харилцагчийн нэрийн өмнөөс нээлттэй буюу шууд эзэмшлийн данс, номиналь данс нээнэ.

#### **Долоо. Гишүүнчлэлийн хураамж, үйлчилгээний хөлс**

7.1 Кастодиан банк нь Төвлөрсөн хадгаламжийн төвтэй 1 жилийн хугацаатай “Төвлөрсөн хадгаламжийн гишүүнчлэлийн гэрээ” (Хавсралт 1) байгуулж, жил бүрийн

тайлант сарын эхний 10 хоног дотор уг гэрээг сунгах хүсэлтийг Төвлөрсөн хадгаламжийн төвд албан тоотоор мэдэгдэнэ.

7.1.1 Кастодиан банк нь Төвлөрсөн хадгаламжийн төвд данс нээлгэхдээ гишүүнчлэлийн хураамж болох 1 000 000 /нэг сая/ төгрөгийг нэг удаа төлөх бөгөөд хураамж төлөгдсөнөөр данс нээх эрх нээгдэнэ.

7.1.2 Кастодиан банк нь Төвлөрсөн хадгаламжийн төвтэй гишүүнчлэлийн гэрээг байгуулсан өдрөөс хойш 10 хоногийн дотор гишүүнчлэлийн хураамжийг Төвлөрсөн хадгаламжийн дансанд байршуулна.

7.1.3 Гишүүнчлэлийн хураамж нь “Төвлөрсөн хадгаламжийн гишүүнчлэлийн гэрээ” (Хавсралт 1)-г сунгахад хамаарахгүй болно.

7.2 Гишүүн нь үнэт цаасны хадгаламжийн үйлчилгээний хөлсийг жил бүрийн эхний 10 хоногийн дотор Төвлөрсөн хадгаламжийн төвийн дансанд байршуулж, Төвлөрсөн хадгаламжийн гишүүнчлэлийн гэрээг сунгасан байна.

7.2.1 Үнэт цаасны хадгаламжийн үйлчилгээний хөлсийг тооцохдоо уг журмын 4.2-т заасан дансанд жилийн эцсийн өдрийн байдлаар хадгалагдаж буй үнэт цаас бүрийн тоо ширхэгийг жилийн сүүлийн сарын сүүлчийн өдрөөс өмнөх 52 долоо хоногийн хаалтын ханшын дундажаар үржүүлж бүх үнэт цаасуудын нийлбэрийн 0.008%-иар шимтгэл бодож авна.

7.2.2 Үнэт цаасны хадгаламжийн үйлчилгээний хөлсийн доод хязгаар 1 000 000 /нэг сая/ төгрөгөөс багагүй, дээд хязгаар 100 000 000 /нэг зуун сая/ төгрөгөөс ихгүй байна.

7.3. Гишүүн нь үйлчилгээний хөлс болох 1 улирлын 250 000 /хоёр зуун тавин мянга/ төгрөгийг төлөх бөгөөд уг үйлчилгээний хөлс төлөгдсөнөөр Төвлөрсөн хадгаламжийн гишүүнчлэлийн гэрээг хүчинтэйд тооцно.

7.3.1 Гишүүн нь Төвлөрсөн хадгаламжийн гишүүнчлэлийн гэрээг төвлөрсөн хадгаламжийн төвтэй байгуулсан өдрөөс хойш 10 хоногийн дотор үйлчилгээний хөлсийг Төвлөрсөн хадгаламжийн төвийн дансанд байршуулна.

### **Найм. Гишүүнийг бүртгэлээс хасах**

8.1 Төвлөрсөн хадгаламжийн төв нь төвлөрсөн хадгаламжид бүртгэгдсэн гишүүнийг бүртгэлээс хасахдаа Хорооны тогтоолыг үндэслэн хэрэгжүүлж, биелэлтийг Хороонд албан бичгээр хүргүүлнэ.

8.2 Гишүүн бүртгэлээс хасагдсан тохиолдолд Хорооны “Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ын 14 дүгээр зүйлд заасны дагуу кастодиан гишүүний үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийг шинэ кастодиан гишүүны дансанд шилжүүлэх ажлыг Төвлөрсөн хадгаламжийн төв гүйцэтгэж, акт үйлдэн 3 хувь баталгаажуулах бөгөөд 1 хувийг Хороонд хүргүүлнэ.

8.3 Тусгай зөвшөөрөл цуцлагдсан кастодиан байгууллагын өмчлөх эрх болон бусад маргаантай асуудлаар Төвлөрсөн хадгаламжийн төв нь Хороонд хандаж шийдвэрлүүлнэ.

### **Ес. Хариуцлага**

9.1 Гишүүн нь энэхүү журмын 5.2-т заасан үүргээ биелүүлээгүйгээс харилцагчидад болон Төвлөрсөн хадгаламжийн төвд учирсан хохирлыг бүрэн хариуцаж, хохирлыг барагдуулна.

9.2 Гишүүн нь уг журмын 5.2-т заасан үүргээ биелүүлээгүй нөхцөлд журамд заасан гишүүнчлэлийн гэрээг цуцалж, Төвлөрсөн хадгаламжийн төв нь төвлөрсөн хадгаламжийн

үйлчилгээ үзүүлэхээс татгалзаж, тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх хүсэлтээ Хороонд гаргана.

9.3 Төвлөрсөн хадгаламжийн төв нь хадгалагдаж буй үнэт цаасыг захиран зарцуулахыг хориглох бөгөөд хадгалагдаж байгаа хөрөнгийн хадгалалтыг хангаагүй бол учирсан хохирлыг хариуцна.

9.4 Төвлөрсөн хадгалмжийн байгууллага уг журмын 5.4-т заасан үүргээ биелүүлээгүй нөхцөлд гишүүн нь төвлөрсөн хадгаламжийн гишүүнчлэлийн гэрээг цуцлах хүсэлтэй байгаагаа Хороонд албан ёсоор мэдэгдэнэ.

9.5 Энэхүү журмын заалтуудыг ноцтойгоор зөрчсөн, “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”, болон Хорооны холбогдох тогтоомжуудыг зөрчсөн, мөн гэмт хэргийн шинжтэй бол хуулийн байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.

Улаанбаатар хот  
2016

## ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ГЭРЭЭ

### Дугаар

... оны ... сарын ... -ны өдөр

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү гэрээгээр талуудын хамтран ажиллах нөхцөл, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” /“ҮЦТХТ”/ ТӨХХК-ийн төвлөрсөн хадгаламжид данс нээх, үнэт цаасны өмчлөх эрх баталгаажуулах, үнэт цаас эзэмшигчийн өмчлөх эрхийн тулгалт хийх, үнэт цаасыг хадгалах, төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбоотой харилцааг зохицуулахаар “ҮЦТХТ” ТӨХХК-ийг төлөөлж ..... болон Кастодиан гишүүнийг төлөөлж ..... байгууллагын ..... овогтой. .... нар харилцан тохирч энэхүү гэрээг байгуулав.

#### Хоёр. Гишүүний эрх, үүрэг

- 2.1 Төвлөрсөн хадгаламжид данс нээлгэхдээ “Кастодианы гишүүнчлэлийн журам”-ын 3 болон 4 дүгээр зүйлд заасан заалтуудыг бүрэн хангасан байна.
- 2.2 Төвлөрсөн хадгаламжид кастодианы хөрөнгө, харилцагчийн хөрөнгөд тус тусад нь зориулсан дансуудыг нээж удирдана.
- 2.3 Кастодиан банк нь төвлөрсөн хадгаламжийн гишүүнчлэлийн хураамжийг төлсөн байна.
- 2.4 Харилцагчийн дансанд хийгдэх гүйлгээний нууцыг хадгалаж, гүйлгээг цаг хугацаанд нь түргэн шуурхай хийлгүүлнэ.
- 2.5 Төвлөрсөн хадгаламжийн дансан дахь үнэт цаас хадгаламжийн мэдээллийг өөрийн хүсэлтийн дагуу гаргуулах эрхтэй.
- 2.6 Гишүүн нь өөрийн хүсэлтээр гишүүнчлэлээс татгалзаж гэрээг цуцлах хүсэлтэй байгаагаа Хороонд албан ёсоор мэдэгдэх эрхтэй.
- 2.7 Гишүүн нь холбогдох ажилтны нэр, албан тушаалын тодорхойлолт, утас, и-мэйл зэргийг төвлөрсөн хадгаламжид албан тоотоор мэдэгдэж байх бөгөөд хэрэв тухайн ажилтан солигдсон эсвэл чөлөөтэй, амралт авсан даруй орлон гүйцэтгэгчийн мэдээллийг тухайн өдөрт нь төвлөрсөн хадгаламжид албан тоотоор мэдэгдэнэ.
- 2.8 Гишүүн нь төвлөрсөн хадгаламжаас авсан тайлан, судалгааг үндэслэж төлбөр тооцоог гүйцэтгэх бөгөөд дараах үйлдлүүдийг хийх боломжтой байна. Үүнд:
  - 2.8.1 Гишүүний харилцагчдын номиналь болон нээлттэй буюу шууд эзэмшлийн (бенефициарь) данс нээх



2.8.2 Гишүүнтэй холбоотой арилжааны хэлцлүүдийг шүүж харах

2.8.3 Гишүүнтэй холбоотой тайлангуудыг өдөр бүр шинээр татаж авах болон шаардлагатай тохиолдолд шинээр дахин гаргуулан авах

- 2.9 Өөрийн харилцагчийн төлбөр тооцоо оройтсон эсвэл төлөгдөөгүй нөхцөлд гарсан үр дагаварын хариуцлагыг кастодиан банк бүрэн хариуцна.
- 2.10 Төвлөрсөн хадгаламжийн системээс хүлээн авсан үнэт цаасны өмчлөх эрхтэй холбоотой тайлан судалгааг өөрийн системийн бүртгэлтэй нягт тулгаж, өдөр бүр бүртгэл хийж байна.
- 2.11 Төвлөрсөн хадгаламжын систем болон албан маягтаар хүлээн авсан мэдээлэл нь өөрийн системийн харилцагчийн үнэт цаасны өмчлөх эрхтэй зөрсөн эсвэл дутсан нөхцөлд талууд харилцан тулгалт хийж, зөрүү аль талд гарсныг Хороонд мэдэгдэж шийдвэрлүүлнэ.
- 2.12 Өдөр өндөрлөх бүрт төвлөрсөн хадгаламжийн Миллениум Ай Ти системээс өөрийн эрхээр хандаж тайлан, судалгааг гаргаж авах бөгөөд хэрэв үнэт цаасны өмчлөх эрх болоод дансны мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд “Кастодианы гишүүнчлэлийн журам”-ын (Хавсралт 3)-ыг бөглөж хуулбарыг ажлын 1 өдөрт багтаан төвлөрсөн хадгаламжид хүргүүлсэн байна.
- 2.13 Үйлчилгээний хөлсийг дараа улирлын эхний 10 хоног дотор төлсөн байна.

#### **Гурав. “ҮЦТХТ” ТӨХХК-ийн эрх, үүрэг**

- 3.1 Кастодиан банкны дансны нууцыг хадгалаж, уг данстай холбоотой мэдээллийг цаг хугацаанд нь түргэн шуурхай кастодиан банкинд мэдэгдэнэ.
- 3.2 Данстай холбоотой мэдээлэл мөн холбогдох хууль дүрэм журамд уг данстай холбоотой заалтад өөрчлөлт орсон тохиолдолд кастодиан банкинд 1 хоногийн дотор мэдээлнэ.
- 3.3 Үнэт цаасны хадгаламж түүнтэй холбоотой мөнгөн гүйлгээний тайлан, судалгааг кастодиан банкинд албан тоотоор ажлын 3 хоногийн дотор мэдэгдэнэ.
- 3.4 Кастодиан банк нь төвлөрсөн хадгаламжийн гишүүнчлэлийн хураамж төлсөн нөхцөлд төвлөрсөн хадгаламж уг төлбөр төлсөн баримтыг кастодиан банкны хүсэлтээр кастодиан банкинд гаргаж өгч болно.
- 3.5 Төвлөрсөн хадгаламжийн дансны үзүүлэлтэд өөрчлөлт орсон тухай бүр кастодиан банкинд системээр мэдэгдэж, 7 хоног бүр тулгалт хийж, маягтын дагуу акт үйлдэж байна.
- 3.6 Кастодиан банктай холбоотой төлбөр тооцооны мэдээлэл, тайлан, судалгааг холбогдох системийн дагуу өдөр бүр “Кастодианы гишүүнчлэлийн журам”-ын (Хавсралт 4)-т тусгасан форматын дагуу кастодиан банкинд гаргаж өгнө.
- 3.7 Төвлөрсөн хадгаламжийн холбогдох ажилтны нэр, албан тушаалын тодорхойлолт, утас, и-мэйл зэргийг гишүүнд албан тоотоор мэдэгдсэн байх бөгөөд хэрэв тухайн ажилтан солигдсон эсвэл чөлөөтэй, амралт авсан даруй орлон гүйцэтгэгчийн мэдээллийг тухайн өдөрт нь гишүүнд албан тоотоор мэдэгдэнэ.

- 3.8 Төвлөрсөн хадгаламжаас кастодиан банкинд хүргүүлсэн төлбөр тооцооны мэдээлэл, тайлан, судалгаа буруу эсвэл илүү, дутуу байвал төвлөрсөн хадгаламж үүнээс үүссэн үр дагаварыг бүрэн хариуцна.
- 3.9 Кастодиан банкны дансанд үнэт цаасны өмчлөх эрх арилжааны бус гүйлгээгээр шилжигдсэн нөхцөлд холбогдох маягтын дагуу акт үйлдэж баталгаажуулан шилжүүлнэ.
- 3.10 Төвлөрсөн хадгаламж нь кастодиан банктай холбоотой үнэт цаасны өмчлөх эрхийн тайлан, судалгааг системийн дагуу хүргүүлж байх бөгөөд кастодиан банк өөрийн эрхээр уг системд нэвтэрч өмчлөх эрхийн болоод бусад холбогдох тайлан, судалгаа, мэдээллийг гаргаж авах нөхцөлийг ямагт бүрдүүлж ажиллана.
- 3.11 Кастодиан банк нь төвлөрсөн хадгаламжийн үйлчилгээний хөлсийг төлсөн нөхцөлд төвлөрсөн хадгаламж уг төлбөрийн төлсөн баримтыг кастодиан банкины хүсэлтээр кастодиан банкинд гаргаж өгч болно.

**Гэрээ байгуулсан:**

“ҮЦТХТ” ТӨХХК-ийг төлөөлж:

“.....” -ийг төлөөлж:

.....

.....

/...../

/...../

Гүйцэтгэх Захирал

Гүйцэтгэх Захирал

Хаяг: Чингэлтэй дүүрэг,  
4-р хороо, Самбуугийн гудамж 16/1

Хаяг: .....  
.....

Утас: 70114424

Утас: .....

Факс: 70114424

Факс: .....

“ҮЦТХТ” ТӨХХК-ийг төлөөлж:

“.....” -ийг төлөөлж:

.....

.....

/...../

/...../

Албаны захирал

Хариуцсан этгээд

Хаяг: Чингэлтэй дүүрэг,  
4-р хороо, Самбуугийн гудамж 16/1

Хаяг: .....  
.....

Утас: 70113671

Утас: .....

Факс: 70114424

Факс: .....

**ГИШҮҮНИЙ ДАНС НЭЭЛГЭХ ӨРГӨДЛИЙН МАЯГТ**  
*/AGREEMENT OF CUSTODIAN BANK ACCOUNT AT THE CENTRAL DEPOSITORY/*

..... оны ..... сарын .....-ны өдөр */Date/*

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ <i>/GENERAL INFORMATION/</i>							
1	Кастодиан нэр <i>/Name of the Custodian/</i>						
2	Байгуулагдсан огноо <i>/Date of Incorporation/</i>		3	BIC Хаяг <i>(BIC Address)</i>			
4	Регистрийн дугаар <i>/Registration No/</i>		5	Улсын бүртгэлийн дугаар <i>/Company ID/</i>			
ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ <i>/CONTACT INFORMATION/</i>							
6	Оршин байгаа байнгын хаяг <i>/Custodian Address/</i>						
7	И-мэйл <i>/Email/</i>		8	Утас <i>/Phone/</i>		9	Факс/ <i>Fax/</i>
БАНКНЫ ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ <i>/BANK INFORMATION/</i>							
10	Банкны нэр <i>/Bank Name/</i>			11	Дансны дугаар болон төрөл <i>/Account Number and type/</i>		
ДАНС ЗАХИРАН ЗАРЦУУЛАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ <i>/TRUSTEE INFORMATION/</i>							
12	Овог <i>/Trustee Surname/</i>			13	Нэр <i>/Trustee Given name/</i>		
14	Регистрийн дугаар <i>/Registration number/</i>			15	Эрхэлсэн ажил <i>/Occupation/</i>		
16	Улсын харьяалал <i>/Country of Residence/</i>			17	Факс <i>/fax/</i>		
18	Утас <i>/Phone/</i>			19	И-мэйл <i>/Email/</i>		
20	Овог <i>/Trustee Surname/</i>			21	Нэр <i>/Trustee Given name/</i>		
22	Регистрийн дугаар <i>/Registration number/</i>			23	Эрхэлсэн ажил <i>/Occupation/</i>		
24	Улсын харьяалал <i>/Country of Residence/</i>			25	Факс <i>/fax/</i>		
26	Утас <i>/Phone/</i>			27	И-мэйл <i>/Email/</i>		
ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖ ДАХЬ ДАНСНЫ ДУГААР (Дотоод хэрэгцээнд) <i>/ACCOUNT NUMBER AT MCSD (Internal use only)/</i>							

Захиран зарцуулагчийн гарын үсэг /Тамга тэмдэг  
*/Trustee Signature /Stamp/*

“ҮЦТХТ” ТӨХХК-ийн ХӨЭБКА-ны ахлах ажилтан  
*/Staff Signature at MCSD/*

Кастодианы захирал /Тамга тэмдэг/ */Director of Custodian /Stamp/*

“ҮЦТХТ” ТӨХХК-ийн ХӨЭБКА-ны захирал

/Director Signature at MCSD/

“ҮЦТХТ” ХХК-ийн Кастодианы гишүүнчлэлийн  
журмын 3 дугаар хавсралт

**КАСТОДИАН ГИШҮҮНИЙ ҮНЭТ ЦААСНЫ ӨМЧЛӨХ ЭРХИЙН БҮРТГЭЛ**  
*/DETAILED SECURITIES HOLDINGS OF CUSTODIAN BANK/*

..... оны ..... сарын .....-ны өдөр /Date/

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ /GENERAL INFORMATION/				
№		Номиналь эзэмшигчийнданс <i>/Nominee account/</i>	хамтын номиналь данс <i>/Collective Nominee Account /</i>	
1	Кастодиан нэр <i>/Name of the Custodian/</i>			
2	Төвлөрсөн хадгаламж дахь дансны дугаар/ <i>Account Number at MCSD/</i>			
ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭЛЭЛ/SECURITIES HOLDINGS INFORMATION/				
№	Үнэт цаасны нэр / <i>Securities Name/</i>	Тоо ширхэг / <i>Quantity/</i>		
		Номиналь эзэмшигчийн данс <i>/Nominee Account /</i>	Хамтын номинальданс <i>/Collective Nominee Account /</i>	
3				
4				
5				
6				
7				
8				
9				
10				
ДОТООД ХЭРЭГЦЭЭНД /INTERNAL USE ONLY/				
11	Хүлээн авсан / <i>Submitted to/</i>			
12	Гарын үсэг <i>/Signature/</i>		13	Огноо / <i>Date/</i>
14	Бүртгэл хийсэн / <i>Register by/</i>			
15	Гарын үсэг <i>/Signature/</i>		16	Огноо / <i>Date/</i>

**КАСТОДИАН ГИШҮҮНИЙ ТАТАЖ АВАХ ФАЙЛЫН ФОРМАТ**  
*/DOWNLOAD FILE FORMAT OF CUSTODIAN BANK/*

### 1.1 Client Registration

Header of the package (record type = 0):

field	length	format	description/example
Date	8	ddmmyyyy	Date of file generation
Member Code	10	X10	Member Code
Member Type	1	X1	Member Type
Total number of records	10	N10	Total number of records in this file
Record type	1	N1	for this record = 0

Transaction (record type = 1):

field	length	format	description/example
Client Prefix	13	X13	Client Prefix
Client Suffix	2	X2	Client Suffix
Client Joint Ac No	2	N2	Joint Ac No of the Client
Member Code	10	X10	Member Code
Member Type	1	X1	Member Type
Title	10	X10	
Initials	20	X20	
Other Names	160	X160	
Surname	50	X50	
Address1	50	X50	
Address2	50	X50	
Address3	50	X50	
Town	20	X20	
Post Code	15	X15	
Country Code	2	X2	ISO country code
Date of Registration	8	ddmmyyyy	Date of registration
Client/ Company ID	13	X13	Client ID
Record type	1	N1	for this record = 1

Footer of the package (record type = 2):

field	length	format	description/example
Record type	1	N1	for this record = 2

### 1.2 Client Holdings

#### 1.2.1 Client Holdings – Per Security

Header of the package (record type = 0):

field	length	format	description/example
Record type	1	N1	for this record = <b>0</b>
Date	8	ddmmyyyy	Date of file generation
Security ID	50	X50	Unique identifier of the security which is generated by the system Eg: Equity: ABL-O-0000 Debt: ABL-BD-16/07/18-C0007-9.5
Security Main Category	1	X1	Category (E,D)
Security Category	1	X1	Security Category If security main category is E (E,F,R) If security main category is D(M,G,C,F,R)
Issuer Code	10	X10	Issuer Code
Debt Type	2	X2	Debt Type if applicable
Security Description	30	X30	Security description
Main Type	1	X1	<b>Not applicable</b>
Sub Type	4	X4	<b>Not applicable</b>
Total number of records	10	N10	Total number of records in this file

Registration (record type = 1):

Field	length	format	description/example
Record type	1	N1	for this record = <b>1</b>
Client Prefix	13	X13	Client Prefix
Client Suffix	2	X2	Client Suffix
Client Joint Ac No	2	N2	Joint Ac No of the Client
Member Code	10	X10	Member Code
Member Type	1	X1	Member Type
Local Client Id	13	X13	NIN of the client
Title	10	X10	
Initials	20	X20	
Other Names	160	X160	
Surname	50	X50	

Account Detail (record type = 2):

Field	length	format	description/example
Record type	1	N1	for this record = <b>2</b>
Account Type	2	X2	All security balances will be included in here. Shadow balance security account will no longer be considered in CSD
Account Description	20	X20	Description of the account
Balance	19	N19	Current balance of the account

Footer of the package (record type = 3):

Field	length	format	description/example
Record type	1	N1	for this record = <b>3</b>

## 1.2.2 Client Holdings – All Securities

Header of the package (record type = 0):

Field	length	format	description/example
Record type	1	N1	for this record = <b>0</b>
Date	8	ddmmyyyy	Date of file generation
Total number of records	10	N10	Total number of records in this file

Security (record type = 1):

Record type	1	N1	for this record = <b>1</b>
Security ID	50	X50	Unique identifier of the security which is generated by the system Eg: Equity: ABL-O-0000 Debt: ABL-BD-16/07/18-C0007-9.5
Security Main Category	1	X1	Category (E,D)
Security Category	1	X1	Security Category If security main category is E (E,F,R) If security main category is D(M,G,C,F,R)
Issuer Code	10	X10	Issuer Code
Debt Type	2	X2	Debt Type if applicable
Security Description	30	X30	Security description
Main Type	1	X1	<b>Not applicable</b>
Sub Type	4	X4	<b>Not applicable</b>

Registration (record type = 2):

Field	length	format	description/example
Record type	1	N1	for this record = <b>2</b>
Client Prefix	13	X13	Client Prefix
Client Suffix	2	X2	Client Suffix
Client Joint Ac No	2	N2	Joint Ac No of the Client
Member Code	10	X10	Member Code
Member Type	1	X1	Member Type
Local Client Id	13	X13	Client/Company ID. i.e. the NIN of the client.
Title	10	X10	
Initials	20	X20	
Other Names	160	X160	
Surname	50	X50	

Account Detail (record type = 3):

Field	length	format	description/example
Record type	1	N1	for this record = <b>3</b>
Account Type	2	X2	All security balances will be included in here. Shadow balance security account will no longer be considered in CSD
Account Description	20	X20	Description of the account
Balance	19	N19	Current balance of the account

Footer of the package (record type = 4):

Field	length	format	description/example
Record type	1	N1	for this record = 4

### 1.3 Transaction file

Header of the package (record type = 0):

field	length	format	description/example
Date	8	ddmmyyyy	Date of report
Member code	10	X10	Member Code
Member Type	1	X1	Member type (Eg: Custodian)
Total number of records	10	N10	Total number of records in this file
Record type	1	N1	for this record = 0

Transaction (record type = 1):

field	length	format	description/example
Date	8	ddmmyyyy	Date of Transaction
Transaction Reference	4000	X4000	Unique Reference to identify a transaction. This is a combination of fields so the length is high. Transactions related to shadow balance security account (i.e. open sell orders) will not be considered.
Transaction category	3	X3	Category of the transaction
Transaction type	3	N3	Type of the transaction
Transaction Type Description	16	X16	Short Name of Transaction Type
Member code	10	X10	Member Code
Client Prefix	13	X13	Client Prefix
Client Suffix	2	X2	Client Suffix
Client Joint Ac No	2	N2	Joint Ac No of the Client
Account type	20	X20	Account type of the client. Shadow balance security account will no longer be considered in CSD
Account sub type	20	X20	Account sub type of the client
Member code (Counter Party)	10	X10	Member Code (Counter party)
Client Prefix (Counter Party)	13	X13	Client Prefix (Counter Party)
Client Suffix (Counter Party)	2	X2	Client Suffix (Counter Party)
Client Joint Ac No (Counter Party)	2	N2	Joint Ac No of the Client (Counter Party)
Account type (Contra Party)	20	X20	Account type of the client (Contra party). Shadow balance security account will no longer be considered in CSD
Account sub type (Contra Party)	20	X20	Account sub type of the client (Contra party)
Security ID	50	X50	Unique identifier of the security which is generated by the system Eg: Equity: ABL-O-0000 Debt: ABL-BD-16/07/18-C0007-9.5
Security Main Category	1	X1	Category (E,D)
Security Category	1	X1	Security Category If security main category is E (E,F,R) If security main category is D(M,G,C,F,R)



Issuer Code	10	X10	Issuer Code of the security
Debt Type	2	X2	Only applicable for D. Leave blank for E
Security Description	16	X16	Short name of the Security.
Main Type	1	X1	Security main type
Sub type	4	X4	Security sub type
Quantity	19	N19	Quantity of the trade
Sign	1	X1	+ or -ve
Record type	1	N1	for this record = 1

Footer of the package (record type = 2):

Field	length	format	description/example
Record type	1	N1	for this record = 2

## 1.4 Contract Note

Header of the package:

field	length	format	description/example
Member code	10	X10	Member Code
Run Date	8	ddmmyyyy	Date when the report is run
Settlement Date	8	ddmmyyyy	Date of settlement
Number of client groups	13	X13	Number of clients
Custodian's net obligation	32	X32	Net obligation of the Custodian

Client group (header):

field	length	format	description/example
Title	10	X10	Title of the Client
Initials	20	X20	Initials of the Client
Other Names	160	X160	Other Names of the Client
Surname	50	X50	Surname of the Client
NIN	13	X13	National Identification Number of the client
Registration ID	32	X32	Registration ID of the client
Net Payable/Receivable	32	X32	Net amount receivable/payable by the client
Number of groups	1	N1	This will always be 2 because there will always be two groups – Trade group and Charge group

Trade group (header):

field	length	format	description/example
Net Trade Payable/Receivable	32	X32	Net amount payable/receivable for the client only for trade settlement i.e. without fees
Record count	10	N10	Number of trades for the client

Trade group details:

field	length	format	description/example
Executed Broker	10	X10	Member Code of the broker who executed the order. For the buy side, the code of the broker who

			executed the buy order will be available here. For the sell side, code of the broker who executed the sell order will be available here
Trade Date	8	ddmmyyyy	Date of the trades
Security ID	50	X50	Security ID of the instrument. this field is not included when this file is downloaded by a bank
Trade ID	10	N10	Unique ID of the trade
Trade Report ID	50	X50	This is the Trade Report ID of a Trade which is reported from the exchange
Buy/Sell	1	X1	Indicates whether the client bought or sold the security
Buy/Sell Custodian Client Reference	50	X50	This is the newly defined, Custodian Client ID which is entered upon order submission as a reference. For buy side, this should be the reference entered at buy order submission, for the sell side this should be the reference entered at sell order submission
Qty	19	N19	Quantity of the trade
Price	10	N11	Price of the trade
Trade Value	32	X32	Trade value
Accrued Interest	13	N13	Accrued interest (applicable only for debt instruments)
Total Value	32	X32	When bonds are traded on Clean Price, this will be Trade value plus accrued interest; when bonds are traded on Dirty Price this will be just the trade value since AI is included in the trade price it self

Trade group (footer):

field	length	format	description/example
Record count	10	N10	Number of trades

Charge group (header):

field	length	format	description/example
Record count	10	10N	Number of fee types
Total Fees	17	N18	Total fees

Charge group details:

field	length	format	description/example
CSD fees	50	X50	Text field with description CSD fees
Value	17	N18	Amount of CSD fees
Exchange fees	40	X40	Text field with description Exchange fees
Value	17	N18	Amount of Exchange fees
FRC_CSD fees	40	X40	Text field with description FRC_CSD fees
Value	17	N18	Amount of FRC_CSD fees
FRC_Exchange fees	40	X40	Text field with description FRC_Exchange fees
Value	17	N18	Amount of FRC_Exchange fees

Charge group (footer):

field	length	format	description/example
Record count	10	N10	Number of fee types

Client group (footer):

field	length	format	description/example
Number of groups	1	N1	This will always be 2 because there will always be two groups – Trade group and Charge group

Footer of the package:

Field	length	format	description/example
Number of client groups	13	X13	Number of clients

## 1.5 Securities master

field	length	format	description/example
Date	8	ddmmyyyy	
Total number of records	10	N10	Total number of records in this file
Record type	1	N1	for this record = 0

Transaction (record type = 1):

field	length	format	description/example
Issuer code	10	X10	Issuer Code
Security ID	50	X50	Security ID
Security Main Type	30	X30	Main Type
Security Sub type	4	X4	Sub type
Security Main Category	10	X10	Category (equity, debt)
Security Category	30	X30	Security Category Eg : Equity, ETF, GDR (if main category is Equity) Government Debt, Municipal Debt. Etc (if main category is Debt)
Security Status	30	X30	Status of the security
Issued Date	8	ddmmyyyy	Date of Issue
Maturity Date	8	ddmmyyyy	Date of Maturity
Security Short Name	16	X16	Short name of the security
Currency Type	30	X30	Currency of the security, this is in ISO currency code
ISIN number	12	N12	ISIN Number
Initial Issue country	30	X30	Issue country of the security, this is in ISO country code
Issued quantity	21	N21	Issued quantity
Reference Price	10	N10	Reference Price
Issued Price/Par Value	10	N10	Issued Price is for Equity securities. Par Value is for the Debt instruments
Multiplier	15	N15	Applicable only for debt instruments; This is the contract multiplier which is a multiple of Par Value

Indexed Quantity	21	N21	Indexed Quantity														
Foreign Holding limit	3	N3	Foreign Holding limit														
Coupon Type	8	X8	The type of the coupon paid for the instrument, can have values like ZR (Zero) /FX (Fixed) /FL (Floating)														
Coupon Rate	3	N3	Coupon rate if the coupon type is not Zero														
Coupon Period	2	N2	This is the Coupon Period of the instrument, field can have following values <table border="1" data-bbox="1003 367 1523 592"> <thead> <tr> <th colspan="2">Mapping</th> </tr> <tr> <th>Value</th> <th>Description</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>0</td> <td>No Interest</td> </tr> <tr> <td>1</td> <td>Annual/End of Term</td> </tr> <tr> <td>2</td> <td>Bi Annual</td> </tr> <tr> <td>4</td> <td>Quarterly</td> </tr> <tr> <td>12</td> <td>Monthly</td> </tr> </tbody> </table>	Mapping		Value	Description	0	No Interest	1	Annual/End of Term	2	Bi Annual	4	Quarterly	12	Monthly
Mapping																	
Value	Description																
0	No Interest																
1	Annual/End of Term																
2	Bi Annual																
4	Quarterly																
12	Monthly																
Issued Spread	12	N12	Issued Spread														
First Coupon Date	8	ddmmyyyy	First Coupon payment date														
Final Coupon Date	8	ddmmyyyy	Final Coupon payment date														
Record type	1	N1	for this record = 1														

Footer of the package (record type = 2):

Field	length	format	description/example
Record type	1	N1	for this record = 2